


Сэдэв: Инкотермсийн FCA нөхцөл






Тээвэрлэгч рүү хүргэх

1. Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнээ “худалдагчийн нэрлэсэн газарт эсвэл талуудын тохирсон өөр нэрлэсэн газарт байгаа худалдан авагчийн томилсон тээвэрлэгч эсвэл хувь хүнд хүргэж” өгөх нөхцөл.
2. Нэрлэсэн газар – Талуудын бараа, бүтээгдэхүүнээ хүргэх, авахаар тохиролцсон нэр, хаяг бүхий газар. Худалдагчийн нэрлэсэн газар нь худалдагчийн албан байр, үйлдвэр, борлуулалтын цэг, агуулах гэх зэрэг худалдагчийн мэдлийн нэр бүхий газрууд юм.
3. Худалдан авагчийн томилсон тээвэрлэгч эсвэл хувь хүн – Бараа, бүтээгдэхүүнийг худалдагчаас хүлээн авч дараагийн тээвэрлэлт рүү зөөж хүргэх эрх бүхий этгээд.



Жишээ: Худалдагчийн нэрлэсэн газарт байгаа худалдан авагчийн томилсон тээвэрлэгч


“ХХХ” ХК-ийн борлуулалтын албаны агуулах,
Үйлдвэрийн гудамж 7, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот- *Худалдагчийн нэрлэсэн газар*



“ХХХ” ХК-ийн борлуулалтын албаны агуулахын үүдэнд 2018 оны
9 сарын 03-ны өдөр “ААА” ХК-ийн 40 тоннын даацтай чингэлэг
ачигч ирж барааны хүргэлтийг авна - *Худалдан авагчийн
томилсон хүргэлт авах тээвэрлэгч эсвэл хувь хүн*

- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг “худалдан авагчийн сонгож томилсон тээвэрлэгч эсвэл хувь хүний мэдэлд” хүлээлгэн өгдөг.
- Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг нэрлэсэн газарт байгаа худалдан авагчийн тээвэрлэгчид хүргэх зардлыг хариуцна.
- Хэрвээ хүргэлтийг худалдагчийн нэрлэсэн газарт хийвэл худалдагч бараа, бүтээгдэхүүнийг сонгосон тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэлд ачаална.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг экспортонд гаргахад шаардлагатай бүрдүүлэлт, үзлэг, шалгалтыг хариуцна.
- Бараа, бүтээгдэхүүн худалдагчаас “сонгосон тээвэрлэгч”-ийн мэдэлд очсоноор эрсдэл худалдан авагч руу шилждэг.
- Худалдан авагч бараа, бүтээгдэхүүнийг анхдагч тээвэрлэгчээс буулгахаас эхлэн хүргэлт дуусах хүртэлх бүх зардлыг хариуцна.

ФСА НӨХЦӨЛИЙН БУДУУВЧ ЗУРАГЛАЛ



Хүлээх үүрэг хариуцлага, зардал

ХУДАЛДАГЧ ХУДАЛДАН АВАГЧ

1. Барааны баглаа, боодол, тэмдэглэгээ, шошго	✓	✗
2. Экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт	✓	✗
3. Хүргэлтийг авах тээвэрлэгч, хувь хүнийг томилох	✗	✓
Хүргэлтийг авах тээвэрлэгч, хувь хүнийг мэдэгдэх	✗	✓
4. Бараа, бүтээгдэхүүн хүргэлт бэлэн байгааг мэдэгдэх	✓	✗
5. Анхдагч тээвэрлэлт (үндсэн тээвэрлэгч рүү)-ийг гэрээлэх, төлөх	✗	✓
Анхдагч тээврийн хэрэгсэлд ачих	✓	✗
Анхдагч тээврийн хэрэгслээс буулгах	✗	✓
6. Үндсэн тээвэрлэлтийг гэрээлэх, төлөх	✗	✓
Үндсэн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах	✗	✓
7. Эцсийн тээвэрлэлт (худалдан авагч руу)-ийг гэрээлэх, төлөх	✗	✓
Эцсийн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах	✗	✓
8. Импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт	✗	✓
9. Даатгал	✗	✗

FCA БОЛОН БУСАД НӨХЦӨЛҮҮД



Талуудын хүлээх үүрэг, төлбөр, хариуцлага, өрсдэл	Худалдагч							Худалдан авагч			
	EXW	FCA	Бүх төрлийн тээвэр					Далайн болон дотоодын усан			
			CPT	CIP	DAT	DAP	DDP	FAS	FOB	CFR	CIF
Зардлын харьцуулсан хэмжээ	\$	\$\$	\$\$\$	\$\$\$	\$\$\$\$	\$\$\$\$	\$\$\$\$\$	\$\$	\$\$	\$\$\$	\$\$\$
Барааны баглаа боодол											
Барааны гэмдэглэгээ, шоошго											
Экспортын зөвшөөрөл											
Ачаа дамжуулагчийн төлбөр											
Үндсэн тээвэрлэгч рүү хүргэх		тохиролцоно									
Үндсэн терминалын хураамж											
Усан нгоцонд ачуулах хураамж											
Усан тээвэр/гаарын тээвэр											
Экспортын бараа дамжуулагчийг сонгох											
Далайн даатгал											
Үндсэн тээвэрлэгчээс ачааг буулгах хураамж											
Очих газрын терминалын хураамж											
Тээвэрлэгчийг сонгох											
Хилээр өрхө шаардлагууд											
Гаалийн үзлэг шалгалтын төлбөр											
Гаалийн хураамж, татвар											
Худалдан авагч рүү хүргэх											
Ачааг буулгах											

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

